



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/49

Хархорин

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2, 3 дугаар багт байрлах 5 нэгж талбарын 4905м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч С.Мөнгөнцэцэг, Г.Цолмон, Ц.Хонгорзул, Ц.Тунгалагтоо, Ж.Мөнхцэцэг нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2021 оны А/228 дугаар захирамжийн А.Амгаабазарын газар эзэмших эрхийн 0000164914 дугаартай гэрчилгээ, 2019 оны А/176 дугаар захирамжийн Д.Аюурзанд холбогдох хэсэг, 2003 оны 63 дугаар захирамжийн М.Ганболдод холбогдох хэсэг, 2018 оны А/183 дугаар захирамжийн Л.Цогбаярт холбогдох хэсэг, 2022 оны А/237 дугаар захирамжийн Ж.Энхтөрт холбогдох хэсэг болон 0000272396, 0024185, 000694617, 0000228216 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100097

ин сумын Засаг даргын
р сарын —ний ө
угаар захирамжийн хав
ЭРС

ЭРС

— 000 —